



ХҮНИЙ ИХ ЭМЧ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Өрхийн их эмч нь өрхийн анагаах ухаанаар төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх;
2. Сум, тосгоны их эмч нь эмнэл зүйн аль нэг үндсэн нарийн мэргэжил /хүүхэд, дотор, эх барих, мэс засал/ эзэмшиж мэргэшсэн байх;
3. Өрхийн эмч нь ажилласан хугацаандаа нэгдүгээр зохиогчоор 2-оос доoshgүй, бусадтай хамтран 2-оос доoshgүй өгүүлэл, илтгэл эрдэм шинжилгээ, судалгааны ажил хэлэлцүүлэн, хэвлэн нийтлүүлж, байгууллагын удирдлага, мэргэжлийн сэтгүүл, илтгэлийн хураангуйн аль нэгээр баталгаажуулсан байх;
4. Сум, тосгоны их эмч нь ажилласан хугацаандаа дангаар болон бусад мэргэжилтэнтэй хамтран 1-ээс доoshgүй удаа ажилдаа дүн шинжилгээ хийж илтгэл бичиж, хамт олноороо хэлэлцүүлэх ба хэвлэн нийтлүүлж баталгаажуулсан байх;
5. Өрх, сум, тосгоны эмч нь ажилласан жилдээ 3-аас доoshgүй мэргэжилтэнг мэргэшүүлэн дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх;
6. Иргэдэд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт 5-аас доoshgүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон баримтыг хавсаргах;
7. Эмч, эмнэлгийн бусад мэргэжилтнүүдэд мэргэжлийн чиглэлээр сургалт, мэдээлэл зохион байгуулж тайланг байгууллагын удирдлагаар баталгаажуулсан байх;
8. Үйлчлэх хүрээний иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг харьяа дээд шатны байгууллага, хөндлөнгийн этгээдээр гаргуулж тус тус хавсаргасан байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Өрхийн их эмч нь өрхийн анагаах ухаанаар төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх;

2. Сум, тосгоны их эмч нь мэргэжлийн чиглэлээр дээшлүүлэх сургалтанд хамрагдаж, ур чадвараа дээшлүүлсэн байх;
3. Өрхийн эмч нь ахлах зэрэг хамгаалснаас хойш хугацаанд нэгдүгээр зохиогчоор 3-аас доошгүй, бусад мэргэжилтэнтэй хамтран 3-аас доошгүй өгүүлэл, илтгэлийг хэлэлцүүлэн, хэвлэн нийтлүүлж байгууллагын удирдлага, илтгэлийн хураангуй, мэргэжлийн аль нэг сэтгүүлд хэвлэн нийтлэгдсэнээр баталгаажуулсан байх;
4. Сум тосгоны их эмч нь ахлах зэрэг хамгаалснаас хойш хугацаанд дангаар болон бусад мэргэжилтэнтэй хамтран эрүүл мэндийн чиглэлээр 2-оос доошгүй удаа илтгэл хэлэлцүүлэх, эсвэл ажилдаа дүн шинжилгээ хийж хамт олноороо хэлэлцүүлэн мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн, түүнийгээ баталгаажуулсан байх;
5. Ажилласан жилдээ 4-өөс доошгүй мэргэжилтэнг мэргэшүүлэн дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх;
6. Шинэ санаа, шинэ бүтээл санаачилан тухайн байгууллагын чанарын албаны ололт амжилтын бүртгэлээр баталгаажсан байх;
7. Иргэдэд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 8-аас доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон баримтыг хавсаргах;
8. Үйлчлэх хүрээний иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг харьяа дээд шатны байгууллага, хөндлөнгийн этгээдээр гаргуулж тус тус хавсаргах.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Өрхийн их эмч нь өрхийн анагаах ухаанаар төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх;
2. Сум, тосгоны их эмч нь мэргэжлийн чиглэлээр дээшлүүлэх сургалтад хамрагдаж, ур чадвараа дээшлүүлсэн байх;
3. Өрхийн эмч нь тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш нэгдүгээр зохиогчоор 5-аас доошгүй, бусад мэргэжилтэнтэй хамтран 8-аас доошгүй өгүүлэл, илтгэлийг хэлэлцүүлэн, хэвлэн нийтлүүлж байгууллагын удирдлага, илтгэлийн хураангуй, мэргэжлийн аль нэг сэтгүүлд хэвлэн нийтлэгдсэнээр баталгаажуулсан байх;
4. Сум, тосгоны их эмч нь тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш хугацаанд нэгдүгээр зохиогчоор 2-оос доошгүй, бусад мэргэжилтэнтэй хамтран 3-аас доошгүй өгүүлэл, илтгэлийг хэлэлцүүлэн илтгэлийн хураангуй болон мэргэжлийн сэтгүүлд хэвлэн баталгаажуулсан байх;
5. Улсын, олон улсын, орон нутгийн чанартай төсөл, судалгааны ажилд судлаач, гүйцэтгэгчээр оролцсон байх /нотлох баримтыг эх хувиар хавсаргах/;
6. Мэргэжлийн дагуу ном товхимол, гарын авлага, CD, DVD зэргийн аль нэгийг гаргаж, зохиогчийн болон оюуны өмчийн эрх авсан байх эсвэл тухайн байгууллагын чанарын албаны ололт амжилтын бүртгэлээр баталгаажсан байх;

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

7. Ажилласан жилдээ 6-аас доошгүй мэргэжилтэнг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх;
8. Шинэ санаа, шинэ бүтээл санаачлан тухайн байгууллагын чанарын албаны ололт амжилтын бүртгэлээр баталгаажсан байх;
9. Иргэдэд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 10-аас доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон баримтыг хавсаргах;
10. Үйлчлэх хүрээний иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг харьяа дээд шатны байгууллага, хөндлөнгийн этгээдээр гаргуулж тус тус хавсаргах.